



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2024/63/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Мөрөн сум 2024 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: [erdenebaatara@audit.gov.mn](mailto:erdenebaatara@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 цахим хаяг: [tegshdelgerb@audit.gov.mn](mailto:tegshdelgerb@audit.gov.mn)

Ахлах аудитор: Б.Давааням

Утас: 92113932 Цахим хаяг: [davaanyamd@audit.gov.mn](mailto:davaanyamd@audit.gov.mn)

Аудитор: Л.Мандахнаран

Утас: 92118277 Цахим хаяг: [MandakhnaranL@audit.gov.mn](mailto:MandakhnaranL@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б			
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	49,878.0	46,422.9	-3,455.1
Бараа материал	462,025.2	408,482.3	-53,542.9
Үндсэн хөрөнгө	3,637,964.5	4,048,389.9	410,425.4
<b>Нийт хөрөнгө</b>	<b>4,149,867.7</b>	<b>4,503,295.1</b>	<b>353,427.4</b>
Өр төлбөр	1,717.9	41,455.5	39,737.6
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	4,148,149.8	4,461,839.6	313,689.8
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>4,149,867.7</b>	<b>4,503,295.1</b>	<b>353,427.4</b>

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,865,196.3 мянган төгрөгийн 10 зөрчил<sup>1</sup> илрүүлж, 2,845.0 мянган төгрөгийн төлбөр барагдуулах 2 төлбөрийн акт тогтоож, 8,109.6 мянган төгрөгийн зөрчлийг таслан зогсоох 2, хариуцлага тооцуулах 1 албан шаардлага өгч, 1,854,241.7 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 5 зөвлөмж хүргүүлээ.

### 5.1 Төлбөрийн акт

1. Тус байгууллага нь 2023 онд төсвийн хөрөнгөөр нийт 345.0 мянган төгрөгийн бэлэг дурсгалын зүйл худалдан авсан байна. Энэ "Төрийн хэмнэлтийн тухай хууль"-ийн 15.1 дэх "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.5 дахь "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах" заалттай нийцээгүй ба "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоов.

2. Тус байгууллагын Нийтлэг үйлчилгээний албаны дарга Б.Батжаргал нь БНХАУ-д томилолтоор ажиллаж 2,500.0 төгрөгийн гадаад томилолтын мөнгийг олгосон байна. Дээрх томилолтын ажлын зорилго, удирдамж нь тухайн албан хаагчийн ажлын чиг үүрэг, албан тушаалд хамааралгүй, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" заалттай нийцээгүй ба "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоов.

### 5.2 Албан шаардлага

1. Тус байгууллагын 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар 5983.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоосон байна. Уг төлбөрийг буруутай албан хаагчаар төлүүлэлгүй байгууллагын төсвөөс төлж барагдуулсан байна. 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар 673.4 мянган төгрөгийг авлагаар тусгаж, 5,309.6 мянган төгрөгийг буруутай албан тушаалтнаас нэхэмжлээгүй байна. Энэ нь өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн актын үндсэн зорилгыг биелүүлээгүй, "Төсвийн тухай хууль"-ийн 16.5.5 дахь "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" заалттай нийцээгүй ба "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул актын төлбөрийг буруутай албан тушаалтнаас нэхэмжилж төлүүлэх албан шаардлага өгөв.

2. Байгууллагын төсвийг зарцуулахдаа нийт 2,800.0 мянган төгрөгийг Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг зөрчсөн байна. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зарлагын эдийн засгийн ангиллыг мөрдөж ажиллах зөвлөмж өгсөн боловч хэрэгжүүлж ажиллаагүй байна. Иймд МУЕА-ын 2021

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10<sup>2</sup> дахь заалтын дагуу албан шаардлага өгөв.

3. Тус байгууллага нь 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр 2023 оны санхүүгийн тайланг Төрийн аудитын байгууллагад ирүүлсэн боловч тухайн тайлан нь үнэн зөв илэрхийлэгдээгүй, ажил гүйлгээ дутуу хангалтгүй нотолгоотой байна. Мөн тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар "сөрөг дүгнэлт" авсан байна. Иймд "Төрийн аудитын тухай хууль"-ийн 42.1 дэх "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно" заалтын дагуу тус байгууллагын төсвийн шууд захирагчид хариуцлага тооцуулах албан шаардлагыг дээд шатны төсвийн захирагчид өгөв.

### **5.3 Зөвлөмж**

#### **1. Шүүхийн шийдвэрийн төлбөртэй холбоотой асуудал**

**Илрүүлэлт:** Хөвсгөл аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 155/ШШ2019/00351 дугаартай шийдвэрийн дагуу Хөвсгөл аймаг дахь ШШГГ-т 22,547.1 мянган төгрөгийг шилжүүлсэн боловч шийдвэр гаргасан буруутай албан тушаалтнаас авах авлагыг бүртгээгүй байна. Энэ нь "Захиргааны ерөнхий хууль"-ийн 103.1 дэх "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай этгээдээр буцааж төлүүлнэ" заалттай нийцээгүй ба "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Буруутай шийдвэр гаргасан албан тушаалтнаас шүүхийн шийдвэрийн төлбөрийг нэхэмжлэх, барагдуулах ажлыг зохион байгуулж ажиллах

#### **2. Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал**

**Илрүүлэлт:** Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ анхны өртгөө нөхөж 0.0 төгрөгийн үлдэгдэлтэй болсон 62 төрлийн хөрөнгө байна. Энэ нь "Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль"-ийн 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх..." заалттай нийцээгүй ба "нийцсэн бөгөөд зохистой" батламж мэдэгдэл хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Дээрх хөрөнгүүдийг дахин үнэлж, цэгцлэх ажлыг зохион байгуулах

#### **3. Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал**

**Илрүүлэлт:** Хөвсгөл аймгийн ахмадын асрамж үйлчилгээний төвд шилжүүлэн ашиглаж байгаа 5,166.7 мянган төгрөгийн дансны үнэтэй Хьюндай Старэкс маркийн автомашиныг данснаас хасаагүй байна. Энэ нь "Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль"-ийн 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх..." заалттай нийцээгүй ба "нийцсэн бөгөөд зохистой" батламж мэдэгдэл хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Дээрх хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг санхүү бүртгэлд тусгах

#### **4. Өр төлбөртэй холбоотой асуудал**

**Илрүүлэлт:** Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар нийт 41,455.5 мянган төгрөгийн харилцагч байгууллагад төлөх өр, төлбөрийн үлдэгдэлтэй байна. Энэ нь "Төсвийн тухай хууль"-ийн 6.4.8 дахь "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" заалттай нийцээгүй ба "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

---

<sup>2</sup> "аудитаар илэрсэн алдаа зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд хэрэгжүүлээгүй бол"

**Өгсөн зөвлөмж:** Төсвийг зохистой удирдаж өр, төлбөр үүсгэхгүй ажиллах

5. Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Байгууллагын нягтлан бодогч нь 2023 оны 2 дугаар улирлын 1,785,072.4 мянган төгрөгийн орлого, зарлагын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэхдээ гүйлгээ бүрээр хөтлөөгүй байна. Орлого, зарлагыг бөөн дүнгээр журналд бичиж бүртгэсэн байна. Энэ нь “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”-ийн 14.4 дэх “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.5 дахь “бүх орлого”, 14.4.6 дахь “бүх зардал” заалттай тус тус заалттай нийцээгүй ба “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Санхүүгийн үйл ажиллагааг гүйлгээ бүрээр бүртгэж ажиллах

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Албан томилолт	1	2,500.0	1	2,500.0								
Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчсөн	1	345.0	1	345.0								
Актын төлбөрийг төсвийн хөрөнгөөр барагдуулсан	1	5,309.6			1	5,309.6						
Өмнөх аудитын зөвлөмжийг биелүүлээгүй	1	2,800.0			1	2,800.0						
Сөрөг санал дүгнэлт авсан	1	-							1	-		
Шүүхийн шийдвэрийн төлбөртэй холбоотой асуудал	1	22,547.1					1	22,547.1				
Үндсэн хөрөнгийг дахин үнэлээгүй	1	-					1	-				
Үндсэн хөрөнгийг ашиглагч байгууллагад шилжүүлээгүй	1	5,166.7					1	5,166.7				
Өр төлбөр үүссэн	1	41,455.5					1	41,455.5				
Ажил гүйлгээ бүрээр бүртгэл хөтлөөгүй	1	1,785,072.4					1	1,785,072.4				
<b>Дүн</b>	<b>10</b>	<b>1,865,196.3</b>	<b>2</b>	<b>2,845.0</b>	<b>2</b>	<b>8,109.6</b>	<b>5</b>	<b>1,854,241.7</b>	<b>1</b>	<b>-</b>		



## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvs gul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2024.02.23 № 01/85  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ  
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
Э.УЛАМ-ӨСӨХ ТАНАА

### Хараат бус аудиторын дүгнэлт

#### Сөрөг дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн мэдэгдэхүйц нөлөөний улмаас Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

1. Байгууллагын нягтлан бодогч нь 2023 оны 2 дугаар улирлын 1,785,072.4 мянган төгрөгийн орлого, зарлагын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэхдээ ажил, гүйлгээ бүрээр хөтлөөгүй, орлого, зарлагыг бөөн дүнгээр журналд бичиж бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 "Аж ахуйн нэгж, байгууллага нь нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө", Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх "Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккруэл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө" заалттай тус тус заалттай нийцээгүй ба "иж бүрэн", "тасалбар болголт" гэсэн батламж мэдэгдлийг тус тус хангахгүй байна.

2. Төсвийн хөрөнгөөр 2023 онд 345.0 мянган төгрөгийн бэлэг дурсгалын зүйл бэлтгэсэн, томилолтын ажлын зорилго, удирдамж нь тухайн албан хаагчийн ажлын чиг үүрэг, албан тушаалд хамааралгүй байхад 2,500.0 мянган төгрөгийн гадаад томилолтын зардлыг олгож төсвийн хөрөнгийн үр ашгийг бууруулсан. Энэ "Төрийн хэмнэлтийн тухай хууль"-ийн 15 дугаар зүйлийн 15.1.5 дахь "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалттай нийцээгүй ба "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

6724040172

### **Асуудлын онцолсон хэсэг**

Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газар нь 2023 оны жилийн эцсийн тайлангаар 41,455.5 мянган төгрөгийн харилцагч байгууллагад төлөх өр, төлбөртэй байна.

### **Аудитын гол асуудал**

Тус байгууллагын 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 5,983.0 мянган төгрөгийн төлбөрийн актыг төсвийн хөрөнгөөр төлж барагдуулсан, төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг мөрдөж ажиллах зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. Мөн 2023 оны завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 55,181.8 мянган төгрөгийн зөрчил илрүүлж 10 зөвлөмжийг хүргүүлснийг хэрэгжүүлээгүй байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга нь Хөвсгөл аймгийн Засаг даргаар 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулж, түүнийг 87.8 хувьтай биелүүлж ажилласан байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А. ЭРДЭНЭБААТАР